

ОРЧУУЛГЫН БЛОГ

ЗӨВХӨН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

2010-09-21

Дундад зууны Монгол Улс Солонгост 4371 боть ном бэлэглэж байжээ.

Монгол, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал саяхан БНСУ-ын Сөүл хотноо болж, шинжлэх ухааны доктор, профессор Б.Сумъяабаатар тус хуралд “Дундад зууны Монгол Улс Солонгос гүрэнтэй номын садан байв” нэртэй илтгэл тавьжээ. Тэрбээр дундад зууны Монгол, Солонгосын харилцааг дан ганц өрсөлдөөн, тэмцэл, хардалт сэрдэлт, үймээн самуун дайн дажны талбар байсан гэж үзэх нь туйлаас өрөөсгөл бөгөөд тухайн үед хоёр орны хувьд соёлын харилцаа онцгой байр эзэлдэг байсан гэдэг санааг түүхэн баримтаар батлан харуулжээ. Түүнээс энэ талаар тодруулсан юм.

Дундад зууны үед манай хоёр орон соёлын онцгой харилцаатай байсан талаар баримт олон бий юү?

-Оюутан суралцуулах, багш мэргэжилтэн илгээх, ном судар солилцох, бичгийн хэрэгсэл өгч, авах, хамтарч ном судар бичих, орчуулж хөрвүүлэх, хэлмэрч орчуулагчдын хөдөлмөр зүтгэлийг үнэлж, хэргэм зэрэг хүртээх, байнга бичиг захидлаар харилцаж байсан тухай түүхэн сурвалж бий. Түүнээс гадна урлаг соёлын тоглолт хийх, урчууд хатгамалчин, эмч домч, бөө удган солилцож байсан зэрэг хэзээ ч үнэ цэнээ алдаж хуучрахгүй түүхэн хуудас тоолж баршгүй. Чухамхүү үүнийг товойлгож дундад зууны Монгол, Солонгос нь эрдэм түгээгч жинхэнэ номын садангууд байсныг баримтаар батлах нь судалгааны маань зорилт юм аа.

-Хэлмэрч, орчуулагчдыг өндөр үнэлж, хэргэм зэрэг хүртээдэг байсан талаар та сонин зүйл хэллээ.

СЭДЭВ

- Ахмадын үгийг сонсьё (26)
- Залуучууд орчуулгын тухай (11)
- Инээгээд авъя (17)
- Монгол бичиг монгол хэл (28)
- Мэдээ мэдээлэл (26)
- Ном толь бичиг (10)
- Орчуулагчдын дүрэм (1)
- Орчуулах эрдэм (27)
- Орчуулгын бизнес (13)
- Хамтран ажиллах (1)
- Хэл шинжлэл (6)
- Хэлэлцүүлэг (3)
- Ярилцлага нийтлэл шүүмжлэл (32)

ТОЛЬ ЛАВЛАХ



700 үг (цэгцэлсэн)

Collocations Dictionary

Daily Writing Tips

HyperGrammar

Академик

Амьтны аймаг

Анагаах, эрүүл мэнд

Англи-герман-англи

Англи-Монгол зүйр цэцэн үгс

Аялал жуулчлал

Байгаль орчин

Бизнес, маркетинг, менежмент

Болор толь

Вики нэвтэрхий толь

Геологи

Геологи (блог)

Гэрээний загварууд (англи)

Дижитал гэрэл зургийн тайлбар
толь

Дуу авианы толь

Дуу чимээний сан

Замын хөдөлгөөний дүрмийн
толь

Зөв бичих дүрэм

Инженер геологийн блог

Инженерийн монгол нэвтэрхий
толь

Криптологи

Латин-англи

Латин-англи-латин

Малтитран

Март

Монгол бичгийн толь

-Монголын хаад ноёд орчуулагчдын эрдэм чадал, авъяас билэг, хөдөлмөр зүтгэлийг нь маш өндөр үнэлдэг байжээ. Өөрийнхөөр зогсохгүй, өрөөлийнхнийг нэн хүндэтгэдэг байсан нэгэн жишээ дурдъя. Хубилай хаан 1272 онд Гуулин улсын ванд илгээсэн зарлигтаа: "Хэлмэрчид Японд очоод гавьяа байгуулсан учир өндөр хэргэм хүртээвээс зохистой" хэмээсэн байдаг. Гуулин улсын ван Хубилай хааны зарлигийг дагаж, нэг хүнд нь жанжин цол олгосон жишээтэй.



-Монголчууд саяхнаас л гадаадад урлагийн тоглолт хийж эхэлсэн гэж боддог. Гэтэл XIII зууны үед тийм тоглолт болж байсан хэрэг үү?

-1282 онд Монголын хэсэг жүжигчид солонгост тоглолт хийж, вангаас нь шагнал хүртэж байсан удаатай. Энэ бол үнэхээр дэлхийн соёлын түүхэнд орох зүйл. Энэ талаар дараа дэлгэрэнгүй ярилцаж болох юм.

-Дундад зууны үед Монгол улс гадаадад номын сан бэлэглэж байсан тухай өмнө нь сонсож байгаагүй юм байна?

-Монголын хаан Солонгосын ванд 17 мянган дэвтэр бүхий 4371 боть ном бэлэглэж байсан түүхэн баримт бий.



Монгол хэлний их тайлбар толь
 Монгол хэлний тайлбар толь
 Монгол хэлний толь бичиг
 Монгол-орос цэргийн түүхийн толь
 Монгол-солонгос-монгол толь
 Монгол-япон хөгжмийн толь
 Монгол, англи толь (Bawden)
 Мэдээллийн технологи
 Мэдээллийн технологи (CSMS)
 Мэдээллийн технологи (Gnome)
 Мэдээллийн технологи (Joomla)
 Найруулга
 Найруулга зүй (англи)
 Найруулгын удирдамж (англи)
 Нягтлан бодох бүртгэл
 Орос хэлний толь лавлах
 Орчуулгын программ
 Санхүү
 Сэтгэл судлалын тайлбар толь
 Товчилсон үг (англи)
 Товчилсон үг (орос)
 Төмөр зам
 Ураг төрлийн нэрийн толь
 Уул уурхайн англи хэл
 Үгийн гарал үүслийн толь (англи)
 Хадмал орчуулгын вэб
 Хакер
 Харь үгийн толь (орос)
 Хими (англи-монгол)
 Химийн блог
 Хоол хүнсний толь

-Хэн гэдэг хаан, хэдэн оны явдал вэ?

-Тэдгээр номыг Солонгосын ван Ү жарны хөх барс жилийн хөх барс өдөр хүлээж авсан байна. Энэ нь 1314 он юм. Тэр үеийн Юань Хөх улсын хаан, тухайлбал, ном бэлэглэсэн монгол хаан нь 1312-1320 он хүртэл ширээнээ заларсан Аюурбарбада буюу Буянт хаан болно. Тэдгээр нь Сүн улсын Нууц сангийн хөлгөн судрууд байсан гэж солонгос сурвалжид тэмдэглэжээ. Энэ түүхэн баримт бидэнд өөр нэгэн зүйлийг өгүүлж байгаа юм. Тэр нь монголчууд харь орныг эзлээд, галдан шатааж, үнсэн товрог болгодог бус эрдэм чадалтай хүмүүсээр зогсохгүй, номын санг нь хүртэл нутаг руугаа зөөж, хямгадан хадгалдаг байсан гэсэн үг. Бараг номын сан бүрдүүлэх шахам ийм олон боть номыг гадаадад бэлэглэж, номын хишиг хүртээж байсан дундад зууны нэг ч орныг би санахгүй байна. Тэгэхээр энэ ч бас дэлхийн соёлын түүхэнд зүй ёсоор бичигдэх ёстой зүйл гэж боддог. Олон түмэн уншиж, ашиглаж, үнэмшин урамшихад нь тус болуужин хэмээн эртний солонгос сурвалжид буй эхийг сонирхуулав.

Г.Гэрэл

"Өнөөдөр" сонин

AT TUESDAY, SEPTEMBER 21, 2010

СЭДЭВ: ЯРИЛЦЛАГА НИЙТЛЭЛ ШҮҮМЖЛЭЛ

ЯМАР БАЙНА? хэрэгтэй (0) сонирхолтой (0) дэмий (0)

NO COMMENTS:

POST A COMMENT

Enter your comment...

Comment as:



[Хүний нэрийн дуудлага](#)
[Хүний нэрийн толь](#)
[Хэвлэлийн нэр томьёо](#)
[Хэл засаг](#)
[Хэлц үг](#)
[Хятад-англи-хятад](#)
[Цахилгаан системийн
автоматжуулалт](#)
[Шувуу](#)
[Эдийн засаг, санхүү](#)
[Этгээд хэллэг, хар яриа](#)

[Newer Post](#)

[Home](#)

[Older Post](#)

Subscribe to: [Post Comments \(Atom\)](#)

БАГАЖ ХЭРЭГСЭЛ

[HTML Editor](#)
[HTML хичээл](#)
[PDF хуудас салгагч](#)
[PDF хэмжээ өөрчлөгч](#)
[PDF хөрвүүлэгч](#)
[Paperrater](#)
[Word Frequency Checker](#)
[Валют хөрвүүлэгч](#)
[Кирилл-монгол хөрвүүлэгч](#)
[Файл дамжуулагч](#)
[Цаг хөрвүүлэгч](#)
[Шилжүүлэгч](#)
[Юникод хөрвүүлэгч](#)
[Ютүбээс татагч](#)

БЛОГ ВЭБСАЙТ

[Албан хэрэг боловсруулалт](#)



 **Бат-Ирээдүй**

4 years ago

 **Билгүүн номчийг дурсахуй**

 **Галаарид**

1 year ago

 **Го. Аким**

1 year ago

 **Гэгээн орчлон**

5 years ago

 **Кино орчуулгын MONGOLSUB баг**

5 years ago

 **Миний эргэн тойронд**

1 year ago

 **Монгол бичгээ сурцгаая**

 **Монгол бичгээрх блог**

2 months ago

Монгол бичиг

 **Монгол бичиг**

1 year ago

Монгол бичиг

 **МОНГОЛ БИЧИГ - МОНГОЛЫН БИЧИГ**

2 years ago

Монгол соёлын төв

 **Монгол хэл, бичгийн багш нарын үндэсний холбоо**

5 years ago

Монголын мэргэжлийн орчуулагчдын нийгэмлэг

 **Монголын мэргэшсэн орчуулагчдын хөгжлийн холбоо**

7 years ago

 **Орчуулах Оролдлого**

6 years ago

 **Орчуулгын клуб**



4 weeks ago

Солонгос хэлний орчуулга
2 years ago

**Та ЕНГЛИШЬ хэл сурмаар
байна уу? (Бүүвэй)**
4 years ago


Хvн Сударын Шогла Дэлгэмv
2 years ago

ЭХ ХЭЛ - БИЧИГ СОЁЛ МИНУ
3 years ago

ӨЛЗИЙ
5 years ago

УНШИГЧ АВГАЙ НАР

Follower (110) [Weiter](#)



Folgen

ТООЛУУР

АРХИВ

September 2010 (12)

